



## ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 26 өдөр

Дугаар А/355

Хэрлэн сум

### Үйл ажиллагааг хөнгөвчлөх зардалд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.3 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны хорин долоодугаар хуралдааны 8 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийгмийн даатгалын үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэх зорилгоор цахимжуулалтын ажлыг гүйцэтгэхэд албан хаагчдын үйл ажиллагааг хөнгөвчлөх, ажиллах нөхцөлийг сайжруулахад 6,000,000 (зургаан сая) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Шаардагдах хөрөнгийг Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн зардлаас олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ